

**УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ТАНХИМД**

2024 оны 6 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Давж заалдах журмаар гомдол гаргах нь

Гомдол гаргагч:

Боржигин овогт Дамбадаржаагийн Янжинхорлоо /ЧП72061807/

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж, 24 дугаар барилгын 6 давхар, 601 тоот. Утас: 9111-1921

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.1 дэх хэсгийн 112.1.4-т заасан тусгай журмаар Захиргааны хэргийн давж заалдах шүүх Д. Янжинхорлоо миний нэхэмжлэлтэй, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо (МӨХ-МХХ)-нд холбогдох, гуравдагч этгээд, өмгөөлөгч Ж. Батхуягийн оролцож буй хэргийг анhan шатны журмаар хянан хэлэлцээд 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр 221/ШШ2024/0011 дугаартай магадлал гаргаж, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шинжийг хангаагүй шийдвэр болсон тул түүнийг бүхэлд нь эс зөвшөөрч энэхүү гомдлыг давж заалдах журмаар гаргаж байна.

Нэг. Шүүх нэхэмжлэлийн агуулга, үндэслэлийн хүрээнд хэргийг шийдвэрлээгүй, нэхэмжлэгчийн шүүхэд мэдүүлэх эрхийг хязгаарласан талаар

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.5 дахь хэсэгт “Шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнээс хэтэрсэн болон хэргийн оролцогчдын маргаагүй асуудлаар дүгнэлт хийж, шийдвэр гаргаж болохгүй”, 106.2 дахь хэсэгт “Шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна” гэж тус тус заасан.

Уг хэрэгт нэхэмжлэгч Д. Янжинхорлоо би МӨХ-МХХ-ны 2023 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн MT/09 дугаартай тогтоолыг хүчингүй болгох тухай нэхэмжлэлийн шаардлагаа дараах үндэслэлийн хүрээнд гаргасан.

Тус хэргээр, Улсын ерөнхий прокурорын газраас өмгөөлөгч Ж. Батхуягт хаяглан хүргүүлсэн 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн хариу мэдэгдэх хуудсыг өөрөө эсхүл бусдаар дамжуулан хүлээн аваад өмгөөллийн тухай хууль тогтоомжоор тусгайлан хүлээлгэсэн мэргэжлийн үүргийг биелүүлээгүйн улмаас тухайн мэдээлэл задарсан, улмаар задарсан болох нь “NEWS.MN” болон бусад олон тооны хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээ, олон нийтийн орчинд тухайн хариу мэдэгдэх хуудас бүрэн хэмжээгээр байршсан байдлаар тогтоогдож, түүнчлэн бодит бусаар гүйвуулан тайлбарлагдаж, Д. Янжинхорлоо миний болон нас барсан нөхөр, насанд хүрээгүй хүүхдүүдийн маань нэр төр, эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдсан, түүнчлэн нэр бүхий нийтийн албан тушаалтнуудын нэр хүндийг зориуд гутаасан мэдээлэл тараагдахад ашиглагдсан нь нотлогдсон байхад Өмгөөллийн тухай хууль тогтоомжоор тогтоосон өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн зөрчил биш гэж МӨХ-МХХ үзсэн нь хууль тогтоомжид илтэд нийцээгүй шийдвэр болсон.

МӨХ-МХХ нь өмгөөлөгч Ж. Батхуяг Өмгөөллийн тухай хууль, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг зөрчсөн зөрчлийг үнэн зөвөөр дүгнэж чадаагүй нь хэрэг

хянан шийдвэрлэх ажиллагааг хангалттай явуулаагүй, шаардагдах баримт нотолгоог бүрдүүлээгүй, холбогдох гэрчүүдийг бүрэн асуугаагүйтэй болон хууль тогтоомжийг зөв тайлбарлан хэрэглээгүйтэй холбоотой байх бөгөөд үүний дагуу Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд тухайн асуудлыг анхан шатны журмаар хянан шалгах явцад өмгөөлөгч Ж. Батхуяг мэргэжлийн зөрчил гаргасан болох нь одоогоор цуглараад буй нотолгооны хэрэгслээр тогтоогдож байна. Тодруулбал:

Нотлогдож буй зөрчил:

Монголын Өмгөөлөгчдийн холбооны Их хурлын 2020 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 8 дугаар тогтоолоор баталсан “Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ийн:

4 дүгээр зүйл /Өмгөөлөгчийн баримтлах нийтлэг зарчим/-ийн 4.1 дэх хэсэгт “Өмгөөлөгч Өмгөөллийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан зарчмыг үйл ажиллагаандaa баримтална”,

10 дугаар зүйл /Нууц хадгалах/-ийн 10.1 дэх хэсэгт “Өмгөөлөгч мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг чанд хадгална”,

18 дугаар зүйл /Мэдээллийн нууцлал/-ийн 18.1 дэх хэсэгт “Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчээс мэдээлэлтэй зөвшөөрөл өгсөн, агуулгаараа нууцад хамаарахгүй, олон нийтэд нэгэнт ил болсон, эсхүл үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахын тулд зайлшгүй задруулах шаардлагатай мэдээллээс бусад үйлчлүүлэгчид хууль зүйн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой мэдээллийг задруулахыг хориглоно”, 18.4 дэх хэсэг “Өмгөөлөгч нь үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой мэдээллийг задруулахаас сэргийлэхэд шаардлагатай арга хэмжээ авна” гэж заасан.

Түүнчлэн тус дүрмийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэгт “...өмгөөлөгч нь энэ дурмийг зөрчсөн үйл ажиллагааны талаар мэдсээр байж түүний үр дагавраас урьдчилан сэргийлэх, эсхүл бууруулах боломжийг ашиглаагүй, шаардлагатай залруулах арга хэмжээ аваагүй бол тухайн зөрчилд зохих хариуцлага хүлээнэ” гэж заажээ.

Мөн Өмгөөллийн тухай хуулийн:

4 дүгээр зүйл /Өмгөөллийн үйл ажиллагаанд баримтлах зарчим/-ийн 4.1 дэх хэсэгт “Өмгөөллийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална: 4.1.1.хууль дээдлэх, шударга ёсыг сахих; 4.1.3.хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хунд, ажил хэргийн нэр хундийг хүндэтгэх; 4.1.4.өмгөөллийн нууц хадгалах; 4.1.6.хүнлэг, энэрэнгүй байх” гэж, мөн хуулийн 14 дүгээр зүйл /Өмгөөлөгчийн үүрэг/-ийн 14.1 дэх хэсэгт “Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараах үүрэг хүлээнэ: 14.1.1.үйлчлүүлэгчид хууль зүйн асуудлаар зөвлөгөө өгч, өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг тухай бүр цаг алдалгүй өгөх, өмгөөллийн үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн агуулга, хууль зүйн үр дагаврыг бүрэн тайлбарлах; 14.1.4.өмгөөллийн нууц, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байх; 14.1.5.хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо холбогдох хуульд заасан журмыг дагаж мөрдөх; 14.1.8.өмгөөллийн үйл ажиллагаанд хууль тогтоомж болон Мэргэжлийн ёс зүйн дүрэм /цаашид “Ес зүйн дүрэм” гэх/-ээр хориглосон үйлдэл, эс үйлдэхүйн талаар үйлчлүүлэгчид тайлбарлах; 14.1.9.үйлчлүүлэгч болон бусад этгээдтэй харилцахдаа хүндэтгэлтэй хандаж, Ес зүйн дурмийг баримтлах;” гэж, мөн хуулийн 15 дугаар зүйл /Өмгөөлөгчид хориглоо зүйл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх/-ийн 15.1 дэх хэсэгт “Өмгөөлөгчид өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх явцад дараах үйл ажиллагааг хориглоно: 15.1.1.өмгөөллийн нууцыг задруулах;” гэж, мөн хуулийн 25 дугаар зүйл /Өмгөөллийн нууц/-ийн 25.1 дэх хэсэгт “Өмгөөлөгчөөс өөрийн үйлчлүүлэгчид үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцаа, тэдгээрийн харилцаатай холбоотой бүхий л баримт

сэлт, мэдээлэл өмгөөллийн нууцад хамаарна”, 25.3 дахь хэсэгт “Өмгөөлөгч өмгөөллийн нууцыг үйлчлүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахыг хориглоно”, 25.4 дэх хэсэгт “Өмгөөллийн нууцыг хугацаагүй хадгална” гэж тус тус заасан.

Өмгөөлөгч Ж. Батхуяг нь дээрх мэргэжлийн үүргийг зөрчсөн болох нь дараах байдлаар нотлогдож байна. Үүнд:

- 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн гэрч С. Чулуунбаатарыг асуусан тэмдэглэлд, С. Чулуунбаатар нь Улсын ерөнхий прокурорын газрын 1/368 дугаартай “Гомдолд хариу өгөх тухай” прокурорын хариу мэдэгдэх хуудсыг “бусдад дамжуулж өгсөн зүйл байгаа юу?” гэх асуултад, “Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд өгч байсан” гэж хариулсан,
- Мөн гэрчийг асуусан тэмдэглэлд, “хариу мэдэгдэх хуудсыг авснаас хойш өмгөөлөгч Ж. Батхуяг тантай хэд хэдэн удаа уулзсан гэсэн тайлбар тавьдаг. Та хоёр хариу мэдэгдэх хуудсыг авснаас хойш уулзсан уу?” гэх асуултад, “Уулзаад явж байсан байх” гэж гэрч хариулсан,
- Мөн гэрчийг асуусан тэмдэглэлд, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, мөрдөн шалгах ажиллагаа, хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл тухайн хуудаст агуулагдаж буй талаар танд өмгөөлөгч Ж. Батхуяг тайлбарлан өгсөн үү?” гэх асуултад хариулахдаа, “Санахгүй байна” гэж гэрч хариулсан,
- Мөн гэрчийг асуусан тэмдэглэлд, “Тухайн мэдээллийг олон нийтэд задруулахгүй байх зохих арга хэмжээг авах шаардлагатай талаар ямар нэгэн зөвлөгөө мэдээллийг өмгөөлөгч Ж. Батхуягаас өгсөн үү?” гэх асуултад “Үгүй” гэж гэрч хариулсан,
- Мөн гэрчийг асуусан тэмдэглэлд, “Хариу мэдэгдэх хуудаст агуулагдаж буй мэдээлэл нь хуулиар хамгаалагдсан ямар ч нууцад хамаarahгүй гэж зөвлөгөө мэдээллийг өмгөөлөгч Ж. Батхуяг өгсөн үү?” гэх асуултад, “Тэр талаар нарийн хэлж байгаагүй” гэж гэрч хариулсан,
- Мөн гэрчийг асуусан тэмдэглэлд, “Улсын Их Хурлын Тамгын газар нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хяналт тавих, мөрдөн шалгах ажиллагааны нууцад хамаарах баримт сэлттэй танилцах эрхтэй байгууллага мөн эсхүл биш талаар ямар нэгэн зөвлөгөө мэдээлэл өмгөөлөгч Ж. Батхуяг танд өгсөн байсан уу?” гэх асуултад, “Үгүй” гэж гэрч хариулсан,
- Мөн гэрчийг асуусан тэмдэглэлд, “Хариу мэдэгдэх хуудас нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт юм. Үүнийг ямар нэгэн хөндлөнгийн этгээдэд задруулж болохгүй шүү гэсэн зөвлөгөөг өмгөөлөгч Ж. Батхуяг өгөөгүй гэж ойлголоо. Зөв үү?” гэх асуултад, “Тийм айхтар нууц гэж ярьж байгаагүй” гэж гэрч хариулсан,
- Өмгөөлөгч Ж. Батхуяг нь МӨХ-МХХ-нд өгсөн тайлбартай (МӨХ-МХХ-ны MT/09 тогтоолын 3-р нүүр, 2-р догол мөр), “Улсын ерөнхий прокурорын газраас хариу гарчихлаа ирж аваарайг гэсэн. Тэр шийдвэрийг гаргасан албан тушаалтны нэр л нууц биш бол тэрэн дээр нууц юм байхгүй. Тэрэн дээр албаны болон хувь хүний нууцтай холбоотой ямар ч материал, мэдээлэл байгаагүй. Энэ дээр төрийн болон албаны нууцын мэдээлэл байхгүй, хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл байхгүй...өгсөн авсандаа буруутгагдаад байх асуудал байхгүй” гэж өөрөө тайлбар өгсөн,
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон өмгөөллийн

нууцад аль алинд хамаарах дээрх хамаарах баримт бичгийн нууцлал нь задарч, улмаар УИХ-ын бүтцийн байгууллага болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд дамжуулагдсан нөхцөл байдлаар тус тус нотлогддог.

Өөрөөр хэлбэл, дээр нотлох баримтуудаас үзэхэд өмгөөлөгч Ж. Батхуяг нь өөрт нь буюу "Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Ж. Батхуяг танд" хэмээн Улсын ерөнхий прокурорын газрын 1/368 дугаартай "Гомдолд хариу өгөх тухай" прокурорын хариу мэдэгдэх хуудсаар хаяглан ирүүлсэн өмгөөллийн нууцад хамаарах баримт бичгийг өөрийн үйлчлүүлэгч С. Чулуунбаатарт дамжуулан өгөхдөө буюу түүгээр дамжуулан аваходаа, цааш бусдад задруулахгүй байх талаар ямар нэгэн зөвлөгөөг өгөөгүй, хууль зүйн үр дагаврыг бүрэн тайлбарлах үүргээ биелүүлээгүй, задруулахаас сэргийлэхэд шаардлагатай зохих арга хэмжээг аваагүй, энэхүү эрсдлийг бууруулах боломжийг ашиглаагүй нь Өмгөөллийн тухай хуулийн 4.1.1, 4.1.3, 4.1.4, 14.1.1, 14.1.4, 14.1.5, 14.1.8, 14.1.9, 15.1.1, 25.1, 25.4, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн 4.1, 10.1, 18.1, 18.4, 33.4-т заасан хориглолт, мэргэжлийн үүрэг, нууц хадгалах үүрэг, мэдээллийн нууцлалтыг задруулахгүй байх талаар зохих арга хэмжээ авах үүрэг, бусад холбогдох зохицуулалтыг зөрчсөн төдийгүй, хожим ч тухайн зөрчлөө ухамсарлан ойлгоогүй, зөвтгөн хамгаалсан байр суурийг илэрхийлж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны болон өмгөөллийн нууцад хамаарч буй баримт бичгийг хувь хүний нууцад хамааралтай ямар нэгэн мэдээлэл агуулагдаагүй, өмгөөллийн нууцад хамаарахгүй гэсэн хууль бус тайлбарыг өгсөөр байгаа нь хууль тогтоомжид нийцэхгүй байна.

Бусад холбогдох зөрчил:

Өмгөөлөгч Ж. Батхуяг нь МӨХ-МХХ-нд тухайн асуудлаар тайлбар өгөхдөө, "Улсын ерөнхий прокурорын орлогч Чинбат гэж хүний шийдсэн асуудлыг тавьснаараа буруудаад байна уу гэж харж байгаа... Улсын ерөнхий прокурорт гомдол өгөхөөр миний гомдол хүсэлтийг шийдвэрлэхээ болилоо, надаас болоод үйлчлүүлэгчийн эрх зүйн байдал дордоод байна... Улсын ерөнхий прокурорт л гомдоор юм" гэсэн байдаг.

Дээрх тайлбарыг өмгөөлөгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх, шалгах чиг үүрэг бүхий Мэргэжлийн хариуцлагын хорооны өмнө бодит тайлбар өгөх үүргийг урьдчилсан сануулсны дараагаар өмгөөлөгч Ж. Батхуяг өгөөд буй нь өөрөө өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн бие даасан зөрчил болсныг МӨХ-МХХ ямар нэгэн байдлаар дүгнээгүй.

"Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм"-ийн 12 дугаар зүйл /Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч болон бусад оролцогчтой харилцах/-ийн 12.1 дэх хэсэгт "Өмгөөлөгч нь шүүгч, прокурор, мөрдөгч, хууль сахиулагч болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцож байгаа бусад оролцогчид¹ зүй бусаар нөлөөлөх эсхүл шийдвэр гаргасных нь төлөө тэднийг сайшаах, буруутгахыг хориглоно" гэж, 32 дугаар зүйл /Гуравдагч этгээдийн эрхийг хүндлэх/-ийн 32.1 дэх хэсэгт "Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлэхдээ гуравдагч этгээдэд хүндрэл учруулах, цагийг нь үрэх, эсхүл тухайн этгээдийн эрхийг зөрчиж үйл ажиллагаа явуулахыг хориглоно". тусгайлан заасныг шууд зөрчсөн.

¹ Прокурорын тухай хуулийн 42.1 дэх хэсэгт "Прокурорын байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн" болохыг нэгэнт хуульчлан тодорхойлсон байна.

Өөрөөр хэлбэл, Улсын ерөнхий прокурорын газар нь өмгөөлөгч Ж. Батхуягийнг тайлбарлаж буйгаар бол, аль нэг маргаантай асуудал үүссэнтэй холбоотойгоор түүний гаргасан аливаа хүсэлт, гомдлыг “шийдвэрлэхээ больсон”, үүнээс шалтгаалж түүний үйлчлүүлэгчдийн “эрх зүйн байдлыг дордуулах” болсон байна. Дээрх дүрмийн 12.1 дэх хэсэгт гэтэл өмгөөлөгч нь прокурор шийдвэр гаргасных нь төлөө тэднийг буруутгахыг хориглоно гэж тусгайлан заасан байхад үүнийг илтэд ноцтой байдлаар зөрчсөн нь тогтоогдож байна.

Үнэхээр өмгөөлөгч Ж. Батхуяг нь чухам нийт хэдэн хэрэг маргаанд өмгөөлөгчийн хувьд оролцож, Улсын ерөнхий прокурорын газарт хүсэлт, гомдол гаргасныг Улсын ерөнхий прокурорын газар ямар нэгэн хариу өгөлгүйгээр шийдвэрлэхгүй орхигдуулсан болох талаар тоо, бүртгэлээс мэдээ авах замаар үүнийг төвөггүй нягтлан тодруулах боломжтой бөгөөд энэ талаар өмгөөлөгч Ж. Батхуяг ямар нэгэн баримт сэлт гаргаж өгөөгүй байдаг. Өмгөөлөгч Ж. Батхуягийн буруутгал ёсоор бол, Улсын ерөнхий прокурорын газар нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо тухайн өмгөөлөгчийн хувийн байдлаас шалтгаалж хуулийг үзэмжээрээ хэрэглэдэг, таалагдахгүй болсон өмгөөлөгчийнхөө хүсэлт, гомдлыг бүхэлд нь шийдвэрлэхгүй орхигдуулдаг, хуйвалдааны шинжтэй байгууллага болсон байна. Энэ бол туйлын ноцтой буруутгал бөгөөд ямар өмгөөлөгч нар прокурорын байгууллагыг хүссэн зоргоороо буруутгаж болдог, ямар өмгөөлөгч нар мэргэжлийн ёс зүйгээ баримталж дүрэм журамд хүндэтгэлтэй ханддаг юм бэ гэж эргэцуулэн бодоход хүргэж байна. Нэг үгээр хэлбэл, Монгол Улсад зарим нэр бүхий өмгөөлөгчдөд өмгөөлөгчийн мэргэжлийн дүрэм журам, хэм хэмжээ нь үйлчилдэггүй, эсхүл нэг мөр бус, ялгамжтай үйлчилдэг, зарим өмгөөлөгчид дархлагдсан байдал бий болоод байна уу гэх эргэлзээ бий болохоор байна.

Гэтэл давж заалдах шатны шүүх уг нэхэмжлэлийн анхан шатны журмаар хянан шийдвэрлээд гаргасан магадлалтай танилцаж үзэхэд, магадлалын “хяnaval” хэсэгт дээр дурдсан нэхэмжлэлийн үндэслэл, агуулга болон шүүх хуралдаанд мэтгэлцсэн асуудлаар тодорхой дүгнэлт өгөөгүй, магадлалын “тодорхойлох” хэсэгт нэхэмжлэгчийн маргасан гол үндэслэлүүдийг тусгаагүй, шүүхэд талуудын мэтгэлцсэн гол асуудлаар дүгнэлт өгөөгүй байдлаар хэргийг шийдвэрлэсэн.

Тодруулбал, магадлалын хяnaval хэсгийн 3 дахь догол мөр хэсэгт, Д. Янжинхорлоо миний гаргасан нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл, агуулгыг шүүх “Өмгөөлөгчийн ёс зүйн дүрмийн 12.1, 14.9, 29.1, 32.1-д тус тус заасныг зөрчсөн” гэж тодорхойлж тухайн хүрээнд үнэлэлт өгсөн. Гэтэл миний нэхэмжлэлд дээрх үндэслэлээс гадна, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн 4.1, 10.1, 18.1, 18.4, 33.4, Өмгөөллийн тухай хуулийн 4.1 дэх хэсгийн 4.1.1, 4.1.3, 4.1.4, 14.1 дэх хэсгийн 14.1.1, 14.1.4, 14.1.5, 14.1.8, 14.1.9, 15.1 дэх хэсгийн 15.1.1, 25.1, 25.3, 25.4 дэх хэсэг, заалтуудыг зөрчсөн талаар холбогдох баримт нотолгооны хамт тусгаж мэтгэлцсэн байхад шүүх хэргийг анхан шатны журмаар хянахдаа нэхэмжлэлд дурдсан үндэслэл бүхий зөрчлүүд гарсан эсэх талаар буюу нэхэмжлэлийн гол маргасан үйл баримтын талаар хяnaval хэсэгт ямар нэгэн дүгнэлт өгөгдөөгүй, хяnaval хэсгийн 4-6.5 дахь хэсэгт өгөгдсөн дүгнэлтүүд дотор нэхэмжлэгч миний маргасан Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн 4.1, 10.1, 18.1, 18.4, 33.4, Өмгөөллийн тухай хуулийн 4.1 дэх хэсгийн 4.1.1, 4.1.3, 4.1.4, 14.1 дэх хэсгийн 14.1.1, 14.1.4, 14.1.5, 14.1.8, 14.1.9, 15.1 дэх хэсгийн 15.1.1, 25.1, 25.3, 25.4 дэх хэсэг, заалтуудыг зөрчсөн гэсэн үндэслэлүүдийн талаар нэг ч дүгнэлт өгөөгүй байна. Энэ нь шүүх нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хэргийг шийдвэрлэх хуулийн зохицуулалтыг баримтлаагүй,

улмаар нэхэмжлэгчийн шүүхэд мэдүүлэх эрхийг үндэслэлгүйгээр хязгаарласныг илэрхийлж байна.

Хоёр. Нотлох баримтыг үнэлэх журмыг илтэд зөрчсөний улмаас хэргийн бодит байдлыг буруу тогтоосон талаар

2.1. Магадлалд “Өмгөөлөгч Ж. Батхуяг нь өөрийн үйлчлүүлэгчдээ мэдэгдэх хуудсыг танилцуулсан нь Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн 12.1 дэх хэсэгт заасан “бусад оролцогчдыг шийдвэр гаргасных нь төлөө сайшаах, буруутгахыг хориглоно” гэх зөрчилд хамаарахааргүй байна” гэжээ. Гэтэл нэхэмжлэгч би өмгөөлөгч Ж. Батхуяг Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн 12.1 дэх хэсэгт заасан зөрчлийг гаргасантай холбоотойгоор ийм утгатай үндэслэл, тайлбарыг нэхэмжлэлдээ бичээгүй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Нотлох баримт нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, бичмэл, цахим баримт, эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, ул мөrnөөс буулгаж авсан хэв, үзлэг, туршилт, танъж олуулах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл зэрэг нотолгооны хэрэгслээр тогтоогдоно” гэж заасан бөгөөд өмгөөлөгч Ж. Батхуяг нь МӨХ-МХХ-нд тухайн асуудлаар тайлбар өгөхдөө, “Улсын ерөнхий прокурорын орлогч Чинбат гэж хүний шийдсэн асуудлыг тавьснаараа буруудаад байна уу гэж харж байгаа... Улсын ерөнхий прокурорт гомдол өгөхөөр миний гомдол хүсэлтийг шийдвэрлэхээ болилоо, надаас болоод үйлчлүүлэгчийн эрх зүйн байдал дордоод байна... Улсын ерөнхий прокурорт л гомдмоор юм” гэсэн байдаг. Уг тайлбарыг өмгөөлөгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх, шалгах чиг үүрэг бүхий Мэргэжлийн хариуцлагын хорооны өмнө бодит тайлбар өгөх үүргийг урьдчилсан сануулсны дараагаар өмгөөлөгч Ж. Батхуяг өгсөн. “Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм”-ийн 12 дугаар зүйл /Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч болон бусад оролцогчтой харилцах/-ийн 12.1 дэх хэсэгт “Өмгөөлөгч нь шүүгч, прокурор, мөрдөгч, хууль сахиулагч болон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцож байгаа бусад оролцогчид зүй бусаар нөлөөлөх эсхүл шийдвэр гаргасных нь төлөө тэднийг сайшаах, буруутгахыг хориглоно” гэж тусгайлан заасныг шууд зөрчсөн. Өөрөөр хэлбэл, Улсын ерөнхий прокурорын газар нь өмгөөлөгч Ж. Батхуягийнг тайлбарлаж буйгаар бол, аль нэг маргаантай асуудал үүссэнтэй холбоотойгоор түүний гаргасан аливаа хүсэлт, гомдлыг “шийдвэрлэхээ болжсон”, үүнээс шалтгаалж түүний үйлчлүүлэгчдийн “эрх зүйн байдлыг дордуулах” болсон гэх буруутгалыг өмгөөлөгч хийсэн байна. Дээрх дүрмийн 12.1 дэх хэсэгт гэтэл өмгөөлөгч нь прокурор шийдвэр гаргасных нь төлөө тэднийг буруутгахыг хориглоно гэж тусгайлан заасан байхад үүнийг илтэд ноцтой байдлаар зөрчсөн нь тогтоогдож байна. Гэтэл шүүх нэхэмжлэгчийн гаргасан тайлбар, гуравдагч этгээдийн тайлбар, хэрэгт авагдсан баримтуудыг дээрхээс өөр утгаар өөрчлөн бичиж, мэдэгдэл танилцуулсныг дүрмийн 12.1 дэх хэсгийг зөрчсөн гэсэн агуулгаар маргасан мэтээр дүгнэлт өгсөн нь нотлох баримтыг үнэлэх журмыг илтэд зөрчсөнийг харуулж байна.

2.2. Хэрэгт авагдсан нотлох баримтууд, тэдгээрийн дотор, 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн гэрч С. Чулуунбаатарыг асуусан тэмдэглэлд, С. Чулуунбаатар нь Улсын ерөнхий прокурорын газрын 1/368 дугаартай “Гомдолд хариу өгөх тухай” прокурорын хариу мэдэгдэх хуудсыг “бусадад дамжуулж өгсөн зүйл байгаа юу?” гэх асуултад, “Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд өгч байсан” гэж хариулсан, мөн гэрчийг асуусан тэмдэглэлд, “хариу мэдэгдэх хуудсыг авснаас хойш өмгөөлөгч Ж. Батхуяг тантай хэд хэдэн удаа уулзсан гэсэн тайлбар тавьдаг. Та хоёр хариу

мэдэгдэх хуудсыг авснаас хойш уулзсан уу?" гэх асуултад, "Уулзаад явж байсан байх" гэж гэрч хариулсан, мөн гэрчийг асуусан тэмдэглэлд, "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, мөрдөн шалгах ажиллагаа, хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл тухайн хуудаст агуулагдаж буй талаар танд өмгөөлөгч Ж. Батхуяг тайлбарлан өгсөн үү?" гэх асуултад хариулахдаа, "Санахгүй байна" гэж гэрч хариулсан, мөн гэрчийг асуусан тэмдэглэлд, "Тухайн мэдээллийг олон нийтэд задруулахгүй байх зохих арга хэмжээг авах шаардлагатай талаар ямар нэгэн зөвлөгөө мэдээллийг өмгөөлөгч Ж. Батхуягаас өгсөн үү?" гэх асуултад "Үгүй" гэж гэрч хариулсан, мөн гэрчийг асуусан тэмдэглэлд, "Хариу мэдэгдэх хуудаст агуулагдаж буй мэдээлэл нь хуулиар хамгаалагдсан ямар ч нууцад хамаарахгүй гэж зөвлөгөө мэдээллийг өмгөөлөгч Ж. Батхуяг өгсөн үү?" гэх асуултад, "Тэр талаар нарийн хэлж байгаагүй" гэж гэрч хариулсан, мөн гэрчийг асуусан тэмдэглэлд, "Улсын Их Хурлын Тамгын газар нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шууд хяналт тавих, мөрдөн шалгах ажиллагааны нууцад хамаарах баримт сэлттэй танилцах эрхтэй байгууллага мөн эсхүл биш талаар ямар нэгэн зөвлөгөө мэдээлэл өмгөөлөгч Ж. Батхуяг танд өгсөн байсан уу?" гэх асуултад, "Үгүй" гэж гэрч хариулсан, мөн гэрчийг асуусан тэмдэглэлд, "Хариу мэдэгдэх хуудас нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт юм. Үүнийг ямар нэгэн хөндлөнгийн этгээдэд задруулж болохгүй шүү гэсэн зөвлөгөөг өмгөөлөгч Ж. Батхуяг өгөөгүй гэж ойлгороо. Зөв үү?" гэх асуултад, "Тийм айхтар нууц гэж ярьж байгаагүй" гэж гэрч хариулсан, өмгөөлөгч Ж. Батхуяг нь МӨХ-МХХ-нд өгсөн тайлбартaa (МӨХ-МХХ-ны MT/09 тогтоослын 3-р нүүр, 2-р догол мөр), "Улсын ерөнхий прокурорын газраас хариу гарчихлаа ирж аваарайг гэсэн. Тэр шийдвэрийг гаргасан албан тушаалтны нэр л нууц биш бол тэрэн дээр нууц юм байхгүй. Тэрэн дээр албаны болон хувь хүний нууцтай холбоотой ямар ч материал, мэдээлэл байгаагүй. Энэ дээр төрийн болон албаны нууцын мэдээлэл байхгүй, хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл байхгүй...өгсөн авсандaa буруутгагдаад байх асуудал байхгүй" гэж өөрөө тайлбар өгсөн зэрэг нотлох баримтуудаар өмгөөлөгч Ж. Батхуяг нь өөрт нь буюу "Монголын Өмгөөлөгчийн холбооны гишүүн, өмгөөлөгч Ж. Батхуяг танд" хэмээн Улсын ерөнхий прокурорын газрын 1/368 дугаартай "Гомдолд хариу өгөх тухай" прокурорын хариу мэдэгдэх хуудсаар хаяглан ирүүлсэн өмгөөллийн нууцад хамаарах баримт бичгийг өөрийн үйлчлүүлэгч С. Чулуунбаатарт дамжуулан өгөхдөө буюу түүгээр дамжуулан аваахдаа, цааш бусдад задруулахгүй байх талаар ямар нэгэн зөвлөгөөг өгөөгүй, хууль зүйн үр дагаврыг бүрэн тайлбарлах үүргээ биелүүлээгүй, задруулахаас сэргийлэхэд шаардлагатай зохих арга хэмжээг аваагүй, энэхүү эрсдлийг бууруулах боломжийг ашиглаагүй нь Өмгөөллийн тухай хуулийн 4.1.1, 4.1.3, 4.1.4, 14.1.1, 14.1.4, 14.1.5, 14.1.8, 14.1.9, 15.1.1, 25.1, 25.4, Өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн 4.1, 10.1, 18.1, 18.4, 33.4-т заасан хориглолт, мэргэжлийн үүрэг, нууц хадгалах үүрэг, мэдээллийн нууцлалыг задруулахгүй байх талаар зохих арга хэмжээ авах үүрэг, холбогдох зохицуулалтыг зөрчсөн нь хангалттай нотлогдсон байхад шүүх дээрх баримтуудыг бүхэлд нь үнэлэхгүй орхигдуулсан нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.2 дахь хэсэгт "Нотлох баримтыг тухайн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв, эргэлзээгүй талаас нь үнэлнэ" гэж заасныг ноцтой зөрчсөн. Гуравдагч этгээд, өмгөөлөгч Ж. Батхуяг нь шүүх хуралдааны асуулт, хариултын шатанд, "Тараасан тараагүйгүйгээс үл хамаараад танд ийм мэргэжлийн үүрэг байсан байна. Хууль зүйн байнгын хороонд өгчихсөн гэдгээ илэрхийлээд байна. Тэгэхээр энийг нь та мэдсэн атлаа яагаад энэ өмгөөллийн дүрэмд заасан үйл ажиллагаагаа, үүргээ огт биелүүлээгүй юм бэ л гэж асууж байна" гэхэд, өмгөөлөгч Ж. Батхуяг "Би тайлбарлаж өгөх шаардлагагүй. Магадгүй тайлбарлаж өгөөгүй гэдэг дээр тайлбарлаж өгөөгүй гэж байгаа бол миний буруутай үйлдэл байж магадгүй" (хуралдааны тэмдэглэл, х.9) хэмээн өөрийн мэргэжлийн алдаагаа өөрөө хүлээн зөвшөөрсөн гэж ойлгогдохоор хариулсан ба өмгөөлөгч Ж. Батхуяг нь ийм байдлаар

алдаагаа хүлээн зөвшөөрсөн, зөвшөөрөгүй эсэхээс үл хамааран дээр дурдсан нотолгооны хэрэгслүүдээр өмгөөлөгчийн ёс зүйн дүрмийн зөрчил гаргасан нь нотлогдож байхад шүүх нотлох баримтыг бүхэлд нь үнэлэхгүй орхигдуулсан нь хуульд нийцэхгүй байна.

Гурав. Нэхэмжлэгчийн нотлох баримт цуглуулах хүсэлтүүдийг шүүх бүрэлдэхүүн “хэрэгт хамааралгүй” гэж хангахгүй орхиж, шаардагдах ажиллагааг хязаарласныхаа дараагаар тухайн үйл баримт “тогтоогдоогүй, нотлох баримт хангалттай бус” гэх үндэслэлээр нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон талаар

3.1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ”, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Өмгөөлөгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоходоо дараах эрх эдэлнэ: 30.3.2.хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримт гаргаж өгөх, хасуулах, шинэ нотлох баримт шаардах;” гэж тус тус зааснаар, нэхэмжлэлийн шаардлагад заасан үйл баримт, үндэслэлийг нотлоход шаардлагатай, өөрсдөө цуглуулах боломжгүй баримтыг шүүх цуглуулах зохицуулалттай байна.

Уг зохицуулалтын дагуу, нотлох баримт цуглуулах, хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай ажиллагааны дараах хүсэлтүүдийг нэхэмжлэгч талаас гаргасан:

3.1.1. Хэргийн хавтсын 11-р талд өмгөөлөгч Ж. Батхуяг нь энэ хэрэгт өөрийн гаргасан тайлбартаа “Улсын Ерөнхий прокурорт гомдол өгөхөөр миний гомдол хүсэлтийг шийдвэрлэхээ больсон, наадас болоод үйлчлүүлэгчийн эрх зүйн байдал дордоод байна уу гэж үзэх боллоо. Улсын Ерөнхий прокурорт гомдмоор юм” гэсэн нь Өмгөөллийн тухай хууль болон өмгөөлөгчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн 12.1 дэх хэсэгт “…шийдвэр гаргасных нь төлөө сайшаах, буруутгахыг хориглоно”), бодит үнэн эсэх нь тодорхойгүй тайлбар болсон тул хэргийн бодит байдлыг тогтоох үүднээс, Улсын Ерөнхий прокурорын газраас 2021 оны 2 дугаар сараас хойш 2023 оны 10 дугаар сарыг хүртэл хугацаанд өмгөөлөгч Ж. Батхуягаас аливаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан Улсын Ерөнхий прокурорын газарт нийт хэдэн удаа гомдол гаргасан, түүнийг хэрхэн, ямар үндэслэлээр шийдвэрлэсэн талаар, түүнчлэн Д. Янжинхорлоотой холбогдох асуудлаас шалтгаалж өмгөөлөгч Ж. Батхуягийн гаргасан гомдлыг “шийдвэрлэхээ больсон” буюу шийдвэрлэхгүй орхигдуулсан, түүний үйлчлүүлэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан тохиолдол байгаа эсэх талаар лавлагаа мэдээлэл, тайлбар гаргуулж өгнө үү гэсэн хүсэлт гаргасныг шүүх “хэрэгт хамааралгүй” гэж хангахгүй орхисон атлаа тухайн зөрчил нотлогдоогүй, зөрчил гаргасан гэх нөхцөл байдал тогтоогдоогүй гэж дүгнэж нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон;

3.1.2. МӨХ-МХХ нь гомдлыг шийдвэрлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчил гаргасан гэж үзэх өөр нэгэн үндэслэл нь Д. Янжинхорлоотой хувийн таарамжгүй харилцаатай МХХ-ны гишүүн Д. Наранцэцэг нь гомдол шийдвэрлэх ажиллагаанд оролцсон гэх үндэслэл буйг нэхэмжлэгч илэрхийлж, МӨХ-МХХ-ны 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн “Өмгөөлөгч Д. Янжинхорлоод холбогдох маргааны тухай” тогтоолтой, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 09 дугаар “Д. Янжинхорлоогийн гомдолтой захиргааны хэргийн тухай” магадлал, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны 2022 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 09 дугаар тогтоол бүхий хэрэгт МӨХ-МХХ-ны гишүүн Д. Наранцэцэг нь Д. Янжинхорлоогийн талаар хэргийг шийдвэрлэж зөвлөлдөж эхлэхээс өмнө урьдаар сөрөг дүгнэлт өгч бусад гишүүдэд танилцуулсан нь тухайн гомдлыг МӨХ-МХХ-ны

хурлаар хэлэлцсэн хуралдааны дуу-дүрсний бичлэгт авагдсан тул тус хэргээс дууджийн бичлэгийг хуралдааны тэмдэглэлийн хамтаар гаргуулах, гаргуулах боломжгүй тохиолдолд үзлэг хийж нотлох баримтаар бэхжүүлэн авч өгнө үү гэсэн хүсэлт гаргасныг шүүх хэрэгт хамааралгүй гэж хангахгүй орхисон;

3.1.3. Өмгөөлөгч Ж. Батхуяг нь өөрийн гаргасан тайлбартаа, Улсын Ерөнхий прокурорын газраас түүнд хаяглан 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдөр өгсөн 1/368 дугаартай албан бичигт Д. Янжинхорлоо нартай холбоотой ямар ч “албаны нууцын мэдээлэл байхгүй, хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл байхгүй” гэж тайлбарласан боловч хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Хувь хүний нууцын тухай хуульд зааснаар тухайн албан бичигт дурдагдсан үйл баримт, мэдээлэл нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны албаны нууц, хувь хүний захидал харилцаа, хөрөнгө, гэр бүлийн болон хуулиар тогтоосон бусад нууцад (мөн хуулийн 4.1), мөн өмгөөллийн нууцад тус тус хамаарах мэдээлэл байдаг. Иймд хэргийн оролцогчдын маргаж буй асуудал болох “мэдээлэл нууцад хамаарах эсэх” асуудлаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1.3, 30.3.3, 31.2 дахь хэсэгт зохицуулсныг удирдлага болгон нууцын асуудлаар Монгол Улсын хэмжээнд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үндсэн чиг үүрэг бүхий Тагнуулын ерөнхий газрыг шинжээчээр томилж, “Улсын Ерөнхий прокурорын газраас өмгөөлөгч Ж. Батхуягт хаяглан 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдөр өгсөн 1/368 дугаартай албан бичиг, түүний агуулга нь албаны нууц болон хувь хүний нууцад хамаарах мэдээ сэлт агуулсан эсэх, эдгээр ангилалд хамаарах эсэх” асуултад тусгай мэдлэгт үндэслэн дүгнэлт гаргаж хариу өгөхөөр шинжээч томилж өгнө үү гэсэн хүсэлтийг хэрэгт хамааралгүй гэж хангахгүй орхисон атлаа, тухайн нэхэмжлэлийн үндэслэл нотлогдоогүй гэж хэрэгсэхгүй болгосон;

3.1.4. МӨХ-MXX нь талуудын маргаж буй үндсэн асуудал болох “мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд хэрхэн тараасан болох” талаар ямар нэгэн нотлох, шалгах ажиллагаа огт явуулалгүйгээр, өмгөөлөгч Ж. Батхуягаас бусадтай харилцаж мэдээллийг цацуулсан эсэх үйл баримтыг шалгалгүйгээр шууд тогтоогдохгүй байна гэсэн дүгнэлт өгсөн нь учир дутагдалтай болсон, хэргийн нэхцэл байдлыг бүрэн дүүрэн тодруулах шаардлагатай байх тул Улсын Ерөнхий прокурорын газраас өмгөөлөгч Ж. Батхуягт хаяглан 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдөр өгсөн 1/368 дугаартай албан бичгийг өгсөн хугацаанаас хойш 2021 оны 5 дугаар сарын 09-ний хүртэл хугацааны 3 сарын хугацаанд Ж. Батхуягийн эзэмшлийн аливаа дансны хуулгыг арилжааны банкуудаас гаргуулж өгнө үү гэсэн хүсэлтийг хэрэгт хамааралгүй гэж хангахгүй орхисон атлаа, тухайн асуудлаар нэхэмжлэлийн үндэслэл нотлогдоогүй гэж хэрэгсэхгүй болгосон нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.3 “Шүүхэд урьдаас хөдөлбөргүй үнэн гэж тогтоогдсон ямар ч нотлох баримт байж болохгүй” гэж заасантай нийцээгүй;

3.1.5. News.agency хэвлэл мэдээллийн байгууллагаас нотлох баримт шүүхийн журмаар гаргуулах тухай: Тус шүүхэд хянагдаж буй Д. Янжинхорлоо миний нэхэмжлэлтэй, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Мэргэжлийн хариуцлагын хороо (МӨХ-MXX)-нд холбогдох, гуравдагч этгээд, өмгөөлөгч Ж. Батхуягийн оролцож буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад, МӨХ-MXX нь уг хэрэгт хамааралтай нэхцэл байдлыг тодруулах үүднээс өмгөөлөгч Ж. Батхуягт УЕПГ-аас хүргүүлсэн прокурорын хариу мэдэгдэх хуудас буюу өмгөөллийн нууцад хамаарах баримт бичгийг ашигласан мэдээллийг дамжуулагч NEWS.MN мэдээллийн сувгийг эрхлэн ажиллуулдаг “Ньюс-Аженси” ХХК /РД: 5406498/-д хандан тухайн баримт бичгийг өгсөн этгээдийг тодруулахаар хандсан боловч тус байгууллага нь мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан байдаг. МӨХ-MXX нь Өмгөөллийн тухай хуулиар байгуулагдсан чиг үүргийн байгууллага бөгөөд тус хуулийн 33.1 дэх хэсэгт зааснаар “Мэргэжлийн хариуцлагын хороо нь шаардлагатай бол хүсэлт, гомдол, мэдээлэлд дурдсан үйлдэл,

эс үйлдэхүйн талаар холбогдох этгээдээс тайлбар, тодорхойлолт авах, Мэргэжлийн хариуцлагын хороонд ирж тайлбар өгөх тухай хүсэлт гаргах эрхтэй бөгөөд холбогдох хүн, хуулийн этгээд нь үнэн зөв тайлбар өгөх үүрэгтэй” гэж зохицуулсан хэдий ч уг асуудлаар нотлох баримтыг гаргуулан авах бүрэн эрх нь шүүхтэй харьцуулахад харьцаангуй хязгаарлагдмал байхаас гадна, дээрх “Ньюс-Аженси” ХХК-ийн татгалзсан хариуг хүлээн авсны дараагаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж хэрэгт зайлшгүй ач холбогдолтой баримтыг албадан гаргуулан аваагүй байна. Иймд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.1, 7.2, 32.1 дэх хэсэгт “Хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах үүргийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэнэ”, 32.2 дахь хэсэгт “Захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргаж өгөхийг шаардах эрхтэй бөгөөд холбогдох этгээд шаардлагыг биелүүлэх үүрэгтэй” гэж тус тус заасныг үндэслэн, түүнчлэн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3.1 дэх хэсэгт “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ” гэж зааснаар тухайн байгууллага нь мэдээлэл дамжуулагчийг шүүхээс нууцлах эрх олгогдоогүй байх тул, “Улсын ерөнхий прокурорын орлогч М. Чинбат нарын прокуроруудын шинж сүлжээ задарлаа”² гэх нийтлэлд байршуулсан Улсын ерөнхий прокурорын газрын 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 1/368 дугаартай прокурорын хариу мэдэгдэх хуудсыг “Ньюс-Аженси” ХХК-д дамжуулан өгсөн, нууцалж буй этгээдийн талаар мэдээллийг гаргуулан авах хүсэлтийг гаргаж байна гэснийг мөн шүүх хангахгүй орхисон атлаа, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон нь нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаа нотлох боломжийг илтэд хязгаарлах замаар хэргийн бодит байдлыг тодруулах ажиллагааг явуулахгүйгээр хэргийг шийдвэрлэснийг илтгэдэг.

Эдгээр хэрэгт зайлшгүй хамааралтай, нэхэмжлэгчийн шүүхэд бичгээр гаргаж өгч буй үндэслэл, тайлбartaа шууд салшгүй холбоотой бүхий л нотлох баримтыг хэрэгт хамааралгүй үндэслэлээр гаргуулах, цуглуулах ажиллагааг явуулахгүй хязгаарласан атлаа, магадлалын 6.3 дахь хэсэгт нэхэмжлэлд дурдсан үндэслэл “тогтоогдохгүй байна” гэж дүгнэж, улмаар 6.5 дахь хэсэгт иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтэд, “нэхэмжлэлийг нотлох баримт хангалттай бус гэж үзэж байгаа бөгөөд үндэслэлгүй гэж үзэж байна” гэснийг шүүх хүлээн авч үнэлсэн болохыг дурдах нь зүйтэй” гэсэн нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг илтэд зөрчсөн, нотлох баримт цуглуулах хүсэлтүүдийг шүүх хангахгүйгээр хязгаарлах, нэхэмжлэгчийг шударгаар шүүлгэх, нотлох баримтыг шалгуулах, цуглуулах эрхүүдийг алдагдуулсан.

Дээрх үндэслэлүүд нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121.3.3-т заасан “анхан шатны шүүх энэ хуулийг зөрчсөн нь шүүхийн шийдвэр гаргахад нөлөөлсөн байвал”, 121.3.4-т заасан “шүүх шаардлагатай нотлох баримтыг дутуу бүрдүүлсэн”, 121.3.5-т заасан “шүүх хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн ба шийдвэрийг өөрчлөх боломжгүй”, 121.3.7-д заасан “шүүх нэхэмжлэлийн болон гуравдагч этгээдийн бие даасан шаардлага, түүний зарим хэсэгт нь дүгнэлт өгөөгүй, эсхүл шийдвэрлэлгүй орхигдуулсан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн” нэхцөл байдалд хамаарч байх тул 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр 221/ШШ2024/0011 дугаартай магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцааж өгнө үү.

Хүндэтгэсэн,
Нэхэмжлэгч Дамбадаржаагийн Янжинхорлоо

² <https://news.mn/r/2410645/>